



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 11707

Улаанбаатар хот

### Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.8 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээг чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ (Р.Амартувшин)-т үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 16,930,000.0 (арван зургаан сая есөн зуун гучин мянга) төгрөгийг "Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын "57"-д батлагдсан "БУСАД" зардлаас холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725023305

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
05 дугаар сарын 16-ны өдрийн  
захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Гадаад харилцааны яамны гаднах явган хүний зам талбайн засвар шинэчлэлийн ажлын зураг төсөв (Улаанбаатар хот)	2025	2025	16.9	16.9
Дүн				16.9	16.9

ନେତ୍ରମିଳିବାରେ କିମ୍ବା ଏବଂ କିମ୍ବା

Digitized by srujanika@gmail.com

(**ପାଦିକାରୀ**) - ୨୩ ମେଲ୍ ମେଲ୍ ମେଲ୍ ମେଲ୍ ମେଲ୍

ବିଦ୍ୟାମରିତି । ଯାହା କଣାରୁ କାହାରୁ ପାଇଲା ତାହାରୁ କାହାରୁ ପାଇଲା ॥ ୧୩ ॥

କୁଣ୍ଡଳ ପରାମାର୍ଦ୍ଦ କରି କରି କାହାରିଟାଙ୍କୁ ନିର୍ମାଣ କରିଛି ?

ଶ୍ରୀମତୀ ପାତ୍ନୀ କଣ୍ଠାରୀ

$$\frac{1}{2\pi i} \frac{\partial}{\partial s} \frac{\pi(s)}{\Gamma(s)}$$

202

ଓঁ শশীলাল মিশন



ପ୍ରାଚୀନ ମହାକାଵ୍ୟାଳୁ